

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН
2022 ОНЫ 01 ДҮГЭЭР ХУРАЛДААН**

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дүгээр хуралдааныг 10 цаг 10 минутад Нутгийн удирдлагын ордны II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 100 хувийн ирцтэй хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	“Аймгийн хошой аварга малчин”, “Аймгийн аварга малчин”, “Аймгийн аварга тариаланч”, “Аймгийн аварга фермер” шалгаруулах тодорхойлолт хэлэлцэх тухай	<p>1. “Аймгийн хошой аварга малчин” 11, “Аймгийн аварга малчин” 79, “Аймгийн аварга саальчин” 6, “Аймгийн аварга тариаланч” 9, “Аймгийн аварга фермер” 1-ийг тус тус шалгуулж, нэрсийг хавсралтаар гаргах;</p> <p>2. Аймгийн Засаг даргын 2017 оны “Журам батлах тухай” А/37 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Аймгийн аварга, хошой аварга малчин” шалгаруулах журмын 4.10, 2 дугаар хавсралтаар баталсан “Аймгийн аварга саальчин” шалгаруулах журмын 4.8, 3 дугаар хавсралтаар баталсан “Аймгийн аварга фермер” шалгаруулах журмын 4.13 дахь заалтад тус тус өөрчлөлт оруулах;</p> <p>3. Журмын дагуу “Аймгийн хошой аварга малчин”, “Аймгийн аварга малчин”, “Аймгийн аварга тариаланч”, “Аймгийн аварга саальчин”, “Аймгийн аварга фермер” нарт олгох энгэрийн тэмдэг, тууз, цар, дурсгалын зүйлийн мөнгөн дүнг тооцож, аймгийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулан танилцуулах;</p> <p>4. Шалгарсан малчин, тариаланч, саальчин, фермерүүдийг олон нийтэд алдаршуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүх, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Бямбажав нарт тус тус үүрэг болгов.</p>
2	Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавар, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэлийн Ховд	<p>Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавар, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэлийн Ховд аймагт холбогдолтой шийдвэрүүдийн 2021 оны жилийн эцсийн хэрэгжилт, явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн талаар хэлэлцэх явцад Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусгаж, www.new.unelgee.gov.mn Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд оруулан баталгаажуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Д.Ариунбилэг, тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Оюунчимэг нарт үүрэг болгов.</p>

	аймагт холбогдолтой шийдвэрүүдийн 2021 оны хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн талаарх танилцуулга	
3	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 оны жилийн эцсийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн талаарх танилцуулга	1. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 оны жилийн эцсийн биелэлт, тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар хэлэлцэх явцад Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусгаж, www.new.unelgee.gov.mn Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд оруулан баталгаажуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Д.Ариунбилэг, тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Оюунчимэг нарт үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР